

МОНГОЛ ОРНЫ ООЧ ЁЛЫН *Gypaetus barbatus* ҮРЖЛИЙН ТАРХАЛТЫН ЗҮҮН ЦЭГИЙН ТАЛААРХ МЭДЭЭ

Даваасүрэнгийн Батмөнх

Зэрлэг амьтан судлах хамгаалах төв, Ундрам Плаза 33 тоот, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар 210349
харилцах хаяг: batmunkh@wscc.org.mn;

abstract. We have recorded a bearded vulture nest in Bayankhuree Mountain in the Bayankhutag sum of Khentii Province. This is the easternmost location of Bearded Vultures breeding in Mongolia.

Keywords: Bearded Vulture, nesting, distribution

Тоодог 1:33, 2014

Дэлхий дээр сэг зэмээр хооллодог 22 зүйл тас шувуу байдгаас (Ferguson-Lees and Christie 2006) манай оронд номрөг тас *Aegypius monachus*, хималайн хажир *Gyps himalayensis*, ухаа хажир *Gyps fulvus*, ооч ёл *Gypaetus barbatus*, дэлт ёлон *Neophron percnopterus* хэмээх таван зүйлийн тас байдаг (Gombobaatar et al. 2011). Эдгээрээс номрөг тас болон ооч ёл нь манай оронд үргжлийн суурин шувууд бөгөөд номрөг тас манай орны дийлэнх нутгаар бусдаасаа харьцангуй түгээмэл тохиолдоно. Харин Ооч ёлын үргжлийн тархалт нь Монгол Алтайн нуруу, Говь-Алтайн нуруу, Хэнтийн нурууны баруун урд хэсэг, Хархираа, Түргэний уулс, Хангайн нуруу зэрэг томоохон уул нуруудаар тохиолддог. Ёл үргжлийн бус улиралд идэш тэжээл хайн тал нутагт үзэгддэг (Фомин ба Болд 1991).

Манай орны Дундад Халхын хээрийн бэсрэг уулсаар ёл шувууны үүр цөөн тоогоор бүртгэгдсэн байдаг. Үүнд Эрдэнэсантын уулс, Батхаан, Хөгнө тарна, Зорголхаан, Хустай, Нагалхаан, Их болон Бага газрын чулуу, Чойрын багд, Хэрлэн Тооно уул, Дархан уул, Язаарын нуруу зэргийг дурьдаж болно (Gombobaatar et al. 2011). Эндээс харахад Ёлын үргжлийн хамгийн зүүн үзүүрийн тархалтын цэг нь Хэнтий аймгийн Баянмөнх сумын Язаарын уулс болж байна.

Бид идлэг шонхорын хиймэл үүр төслийн мониторингийн үеэр Хэнтий аймгийн Баянхутаг сумын нутагт байх Баянхүрээ уулын энгэрт ооч ёл үүрлэсэн байхыг олж тэмдэглэлээ. Үүрэн дээр ойролцоогоор 3 настай гүүжилт нь хараахан гүйцээгүй байгаа залуу ёл байсан. Баянхүрээ уул нь (N 47.3600, E 111.3700) далайн төвшинөөс дээш 1450 м өргөгдсөн. Үүр байрлаж байсан элгэн хад босоогоор

50м орчим, өргөнөөр 300м орчим бөгөөд ёлын үүр нь газраас дээш 20м орчимд хадны хонхор хүнхээгт байрлаж байсан. Бид үүрийг очиж шалгаж чадаагүй. Үүрлэсэн үүрний материал, ашиглагдсан байдал, сангас зэргээс харахад энэ үүр өмнөх жилүүдэд ашиглагдаж байсан шинжтэй байв. Залуу шувуу үүрнээсээ ниссэнээс хойш урт хугацааны турш төрж өссөн үүрээ эргэж тойрдог зан төрхтэй бөгөөд энд ашиглагдсан залуу шувуу нь энэхүү үүрний шувуу байх боломжтой юм. Энэ үүр бидний үзэж буйгаар одоогоор Монголд бүртгэгдээд байгаа ооч ёлын үргжлийн хамгийн зүүн цэг болж байна.

Ашигласан бүтээл

Ferguson-Lees, J., and D. A. Christie. 2006. *Raptors of the World*. Princeton University Press.

Gombobaatar, S., E. M. Monks, R. Seidler, D. Sumiya, N. Tseveenmyadag, S. Bayarkhuu, J. E. M. Baillie, S. Boldbaatar, and C. Uuganbayar, editors. 2011. *Regional Red List Series Vol.7. Birds*. Zoological Society of London, National University of Mongolia, and Mongolian Ornithological Society.

Фомин, В. Е., ба А. Болд. 1991. Каталог птиц Монгольской Народной Республики. Наука, Москва.